



# НЕПАЛ: ХООЛ ХҮНСТЭЙ БАЙХ ЭРХ БА ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2018 ОН: ХООЛ ХҮНСТЭЙ БАЙХ ЭРХ БА ХҮНСНИЙ ТУХАЙ  
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ



**Эмнести Интернэшнл бол хүн бүр эрхээ эдэлдэг дэлхийн ертөнцийг бий болгохын төлөө 7 сая гаруй гишүүд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм.**

**Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан бүхий л эрхийг хүн бүрд эдлүүлэх нь бидний эрхэм зорилго билээ.**

**Бид төрийн засгийн аливаа байгууллага, улс төрийн үзэл хандлага, эдийн засгийн эрх ашиг болон шашны үзлээс бүрэн ангид, хараат бус байгууллага бөгөөд гишүүд дэмжигчид хийгээд олон нийтийн хандив, дэмжлэгээр санхүүждэг болно.**

©Эмнести Интернэшнл 2019

Энэ сэтгүүлд тусгагдсан бүтээлүүд Бүтээлч Хамтын Өмчид харьяалагдана. (зохиогчийн нэрийг дурдана, худалдахгүй, хуулбарлахгүй, олон улсын 4.0 зөвшөөрөл)  
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудсаас авна уу:  
[www.amnesty.org](http://www.amnesty.org)

Зохиогчийн эрхийг Эмнести Интернэшнл хэмээн заагаагүй тохиолдолд Бүтээлч Хамтын Өмчийн зөвшөөрөл олгохгүй.  
2019 онд анхлан хэвлэгдэв.  
Amnesty International Ltd  
Ийстон Гудамж 1, Петер Бененсоны Ордон  
Лондон хот WC1X 0DW, UK



*Cover photo: Birgunj, Nepal - February 17, 2013: A woman in a blue sari is processing mustard seeds in a village near Birgunj.*  
© Christian Ender/Contributor/Getty Images

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

Индекс: ASA/31/0130/2019

Эх хэвлэлийн хэл: Англи

[amnesty.org](http://amnesty.org)

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ



# АГУУЛГА

<b>1. ОРШИЛ</b>	<b>2</b>
<b>2. ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ</b>	<b>3</b>
<b>3. ҮНДСЭН ХУУЛИЙН АМЛАЛТ</b>	<b>6</b>
<b>4. ХУУЛИЙН НЭМЭЛТ ТАЙЛБАР</b>	<b>8</b>
4.1. ХУУЛЬ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ЦАР ХҮРЭЭ	8
4.2. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	9
4.3. ХУУЛЬ ЁСНЫ БАТАЛГАА	10
4.4. ӨЛБӨРӨХӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ	11
4.5. ТУСЛАЛЦАА ДЭМЖЛЭГ ШААРДЛАГАТАЙ ӨРХҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ХҮНСНИЙ ТУСЛАМЖ	12
4.6. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ НЬ	13
4.7. ТАРИАЧДЫН ЭРХ	13
4.8. ТАРИАЛАН ЭРХЛЭХ ГАЗРЫН ТОГТВОРТОЙ АШИГЛАЛТ	14
4.9. ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	15
4.10. ҮНДЭСНИЙ, БҮС НУТГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ ЗАСГИЙН ГАЗРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА	16
4.11. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА БА ХӨГЖИЛ	16
4.12. ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	16
4.13. ЗОХИЦУУЛАХ МЕХАНИЗМ	17
4.14. ГЭМТ ХЭРЭГ БА ЯЛ ШИЙТГЭЛ	17
4.15. НӨХӨН ОЛГОВОР	18
4.16. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ	18
<b>5. ДҮГНЭЛТ</b>	<b>19</b>

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

# 1. ОРШИЛ

Непал улсын 2015 онд батлагдсан Үндсэн хуулийн 36-р зүйлд заасан “хоол хүнстэй байх эрх”-ийг хэрэгжүүлэхээр 2018 онд “Хоол хүнстэй байх эрх ба хүнсний тухай хууль” (цаашид Акт гэх) батласныг Эмнести Интернэшнл сайшаан хүлээн авч байна. Тус улсын ерөнхийлөгч батламжилснаар энэ Акт 2018 оны 9 сарын 18-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болжээ.

Непал улсын хэмжээнд өрхийн хүнсний аюулгүй байдал дөнгөж 48.2 %, <sup>1</sup> хүн амын 21.6% нь ядуу амьдралтай, хүн амын ойролцоогоор 41% нь хоол хүнснээс авах хамгийн бага илчлэгээ ч авч чаддаггүй ба бараг хоёр сая орчим хүн хоол тэжээлийн дутагдалтай гэж үзсэн байна. 5 хүртэлх насны хүүхдийн 36% нь хоол тэжээлийн хурц дутагдалд орсон байх ба мөн 5 хүртэлх насны хүүхдийн 53% нь цус багадалттай (6% нь бага зэргийн, 26% нь дунд зэргийн, 1% хүнд хэлбэрийн<sup>2</sup>) байна. Непалын засгийн газар дээр дурдсан өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдал болон хүнсний баталгаагүй байдлын асуудлыг шийдвэрлэхээ амлаад байгаа билээ.<sup>3</sup>

Үндсэн хуулийн 36-р зүйл болон Үндсэн хуулиар баталгаажсан бусад эрхүүдийг бодитоогоор эдлүүлэхийн тулд хуулийн эрүүл зөв тогтолцоо, мөн хуулийг үр дүнтэйгээр хэрэгжүүлдэг байх хэрэгтэйг Эмнести Интернэшнл онцолж байна. Хоол хүнсний тухай Акт болон Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пакт (ЭЗНСЭОУП)-аар Непал улсын хүлээсэн үүрэг хариуцлага зэргийг харьцуулан Эмнести Интернэшнлээс Хоол хүнстэй байх эрх ба хүнсний хараат бус байдлын тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ хийж, тус улсын засгийн газарт эрх зүйн тогтолцоогоо бэхжүүлэх, батласан хуулиа хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх зорилгоор дараах санал, зөвлөмжүүдийг өгч байна.

Эмнести Интернэшнлийн зүгээс тус хуулийн давуу болон сул талуудыг тодорхойлох, хуулийн батлагдсан заалтуудыг шуурхай хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Непалийн иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг дэмжих асуудлыг мөн санал болгожээ.<sup>4</sup>

Эмнести Интернэшнлийн зүгээс ялгаварлагдан гадуурхагдсан болон хоол хүнсээр хангагдах эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгийнхнийг оролцуулаад, хүн бүрийн хангалттай хоол хүнсээр хангагдах эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд Акт дахь олон чухал асуудлууд (жишээ нь, нэр томъёоны тодорхойлолт, өлсгөлөнтэй холбоотой хүний эрхийн зөрчилд хүлээх хариуцлага, хэрэгжилтийн механизм дахь хүртээмж зэрэг)-д анхаарлаа хандуулахыг Непалын засгийн газарт уриалж байна.

<sup>1</sup> ХХААЯ, Газрын харилцаа болон Хоршоодын бэлтгэн гаргасан 2018 оны Хүнс, Хоол тэжээлийн нөхцөл байдлын тайланг үз. [http://moad.gov.np/public/uploads/1749913226-St%20Rep\\_%20Food%20and%20Nutrition%20Secu.pdf](http://moad.gov.np/public/uploads/1749913226-St%20Rep_%20Food%20and%20Nutrition%20Secu.pdf)

<sup>2</sup> Непалын засгийн газар, Үндэсний төлөвлөлтийн хорооноос гаргасан “Непал дахь өлсгөлөнг устгах нь – Хүнс, тэжээлийн аюулгүй байдалд хийсэн стратегийн үнэлгээ” 2018-г үз. <https://reliefweb.int/report/nepal/towards-zero-hunger-nepal-strategic-review-food-security-and-nutrition-2018>

<sup>3</sup> Жишээ нь, ТХЗ-уудыг хэрэгжүүлэх тус улсын амлалт (ТХЗ 2: өлсгөлөнг устгаж, хүнс, тэжээлийн аюулгүй байдлыг хангаж, хүнсний тэжээллэг байдлыг нэмэгдүүлж, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлнэ).

<sup>4</sup> 2018 оны 11 сарын 1-ний өдөр болсон семинар болон 2018 оны 10 сарын 12-13-ны өдрүүдэд Хууль зүй, Эрхийн Институт, Олон нийтийн бие даасан байдлын төв болон тус улсын Хоол хүнстэй байх эрхийн сүлжээ, ЭЗНСЭОУП-ын Үндэсний сүлжээнээс хамтран зохион байгуулсан “Үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн хуулиуд” Экспертийн үнэлгээ дүгнэлт өгөх семинарын дараа 2018 оны 12 сарын 11-ний өдөр иргэний нийгмийн байгууллагуудын бүлгийн зүгээс одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад (Хоол хүнстэй байх эрх ба хүнсний тухай хууль, Газар болон орон байртай байх эрхийн тухай хууль /7 дахь нэмэлт өөрчлөлт/) өөрсдийн санал бодлыг тусгасан санамж бичгийг Хууль зүйн Яамны сайдад өргөн барьсан байна.



## 2. ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ

Непал улс ЭЗНСЭОУП зэрэг олон улсын хүний эрхийн гол гэрээ конвенциудад нэгдэн орж, хүний бүхий л эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүрэг хүлээсэн билээ.

ЭЗНСЭОУП-ын 11.1 дэхь хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон тэдгээрийн өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон байрыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралын нөхцлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд энэ талаар чөлөөтэй зөвшилцөлд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна.” гэж заасан байдаг.

Түүнчлэн, 11.2 дахь хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсгөлөнгөөс ангид аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэх, дангаараа болон олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр шаардлагатай арга хэмжээг дараах зорилгоор авна. Үүнд:

(а) байгалийн эх нөөцийг хамгийн үр ашигтай эзэмших, ашиглах зорилгоор техник, шинжлэх ухааны мэдлэгийг өргөн ашиглах, хүнс тэжээлийн тухай мэдлэгийг дэлгэрүүлэх, газар тариалангийн тогтолцоог боловсронгуй болгох, шинэтгэл хийх замаар хоол хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, хуваарилах арга ажиллагааг сайжруулах;

(b) хүнсний бүтээгдэхүүн экспортлогч буюу импортлогч улсын асуудлыг анхааралдаа авч харгалзан дэлхийн хоол хүнсний нөөцийн шударга хуваарилалтыг хангах.

Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо (ЭЗНСЭХ)-ноос хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эрх ба энэ тухайд улс орнуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгосон билээ.<sup>5</sup>

Хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эрхийг хангах үүргээ биелүүлэхийн тулд улс орнууд өлсгөлөнгийн асуудлыг нэн даруй шийдвэрлэж, “эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд бүр, дангаараа болон нийгмийн бүлгээрээ цаг үргэлж хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эдийн засгийн болон бодит боломжтой байх, мөн худалдан авах арга хэрэгслээр хангагдсан байх” боломжийг шат дараатай авч хэрэгжүүлэх.<sup>6</sup>

<sup>5</sup> ЭЗНСЭХ, 12-р Ерөнхий санал зөвлөмж, Хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эрх, НҮБ-ын баримт бичгүүд E/C.12/1999/5. Бусад холбогдох Ерөнхий санал зөвлөмжүүд, Усны эрхийн талаарх 15-р Ерөнхий санал зөвлөмж НҮБ-ын баримт бичгүүд, E/C.12/2002/11.

<sup>6</sup> ЭЗНСЭХ, 12-р Ерөнхий санал зөвлөмж, Шаардлагад нийцсэн хоол хүнстэй байх эрх, 6-р догол мөр.

Хоол хүнсээр хангах эрхийг эрхийг ухамсарлахын тулд улс орнууд дараах зүйлсийг хангах шаардлагатай:

- **Хүрэлцээтэй байдал:** үржил шимтэй газар болон байгалийн бусад нөөцөөс, эсвэл сайн хөгжсөн боловсруулах, түгээх зах зээлийн системээс өөрийгөө шууд хүнсээр хангах боломж. Үүнд тухайн улсын олон улсын хэмжээнд бусад улсуудын хоол хүнстэй байх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хоол хүнсэнд хүрэх боломжийг бий болгох болон шаардлагатай үед тусламж үзүүлэх зэрэг багтана.<sup>7</sup>
- **Хүртээмжтэй байдал:** эдийн засгийн хүртээмжтэй байдал (зохистой татаас болон тусламж зэрэг эдийн засгийн үйл ажиллагаагаар дамжуулан) болон бодит боломжит байдлын (ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст) аль алиныг ойлгоно. Нийгмийн хувьд эмзэг байдалтай, өөрөөр хэлбэл боломж, бололцоогоор дутагдаж байдаг хүмүүст тусгай хөтөлбөрөөр дамжуулан анхаарал тавих шаардлагатай байж болох юм. Үүнд байгалийн гамшигт өртөгсөд болон гамшигт өртөмтгий бүс нутагт амьдардаг хүмүүс орно.
- **Хүлээн авах боломжтой байдал:** “Хүмүүсийн хоол хүнсний хэрэгцээг бүрэн хангахуйц чанар болон тоо хэмжээний хувьд шаардлага хангасан хүнсний хүрэлцээ, олдоцтой байдал бөгөөд тухайн соёлд хүлээн авах боломжтой байдлыг ойлгоно.”<sup>8</sup>

Непал улс нь Пактад оролцогч улсын хувьд: а) хангалттай хэмжээний хоол хүнстэй байх боломжид саад болохоос зайлсхийх, б) гуравдагч талууд (төрийн бус)-ын зүгээс хүмүүсийг хангалттай хэмжээний хоол хүнстэй байх боломжоос нь салгахгүй байх явдлыг баталгаажуулах, с) онцгой байдлын болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан өөрсдийгөө хүнсээр хангаж чадахгүй байгаа хүмүүсийг наад захын, үндсэн хоол хүнсээр хангах, хүнсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхийн тулд идэвхитэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зэргээр хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эрхийг хүндэтгэн үзэх, хамгаалах, биелүүлэх шаардлагатай.<sup>9</sup>

ЭЗНСЭОУП-д онцлон авч үзсэнчлэн, хүний эрхийн наад захын, зарим суурь элементүүд<sup>10</sup> (жишээ нь, өлсгөлөнгөөс ангид байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх баталгаа болон ундны цэвэр усны хүртээмж)<sup>11</sup>-ийг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хангалттай нөөц байхгүй үед ч хоол хүнсээр хангагдах хүний үндсэн эрхийн наад захын эрхийг хангахын тулд хүчин чармайлт гаргах нь төрийн үүрэг хэвээр байна.<sup>12</sup>

Хангалттай хоол хүнсээр хангагдах эрх нь Непал улсын соёрхон баталсан, заавал биелүүлбэл зохих бусад гэрээнүүдийн нэг хэсэг юм. ЭЗНСЭОУП-ын 6-р зүйлээр баталгаажсан хүний аж төрөх эрхийн талаар оролцогч улсууд “нялхсын эндэгдлийг бууруулах, хоол тэжээлийн дутагдал болон халдварт өвчний тархалтыг бууруулах замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэх”-д чиглэгдсэн үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооноос тайлбарласан байдаг.<sup>13</sup>

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (ЭЯГБХУК)-д эмэгтэйчүүд жирэмсэн болон хөхүүл байх үедээ хангалттай тэжээллэг хоол хүнс

<sup>7</sup> ЭЗНСЭОУП, 12-р Ерөнхий санал зөвлөмж, 36-р догол мөр

<sup>8</sup> ЭЗНСЭОУП, 12-р Ерөнхий санал зөвлөмж, 8-р догол мөр

<sup>9</sup> ЭЗНСЭОУП, 12-р Ерөнхий санал зөвлөмж, 15-р догол мөр

<sup>10</sup> ЭЗНСЭОУП, 12-р Ерөнхий санал зөвлөмж, 14, 17-р догол мөр. Пактад дурдсанаар, хүний суурь эрхийн “наад захын үндсэн” хэмээх ойлголт нь төрийн зүгээс иргэдийн хамгийн нэн тэргүүний хэрэгцээнд эхний ээлжинд анхаарлаа хандуулах ёстой гэсэн санаа юм.

<sup>11</sup> ЭЗНСЭОУП, 3-р Ерөнхий санал зөвлөмж, Ундны усаар хангагдах эрх (ЭЗНСЭОУП-н 11, 12-р зүйл), 37-р догол мөр

<sup>12</sup> ЭЗНСЭОУП, 3-р Ерөнхий санал зөвлөмж, Оролцогч улсуудын үүргийн мөн чанар (5-р хуралдаан, 1990 он), НҮБ-ын баримт бичиг, E/1991/23

<sup>13</sup> НҮБ-ын Хүний эрхийн хороо, Аж төрөх эрхийн талаарх 6-р санал зөвлөмж, 5-р догол мөр

хэрэглэх эрх,<sup>14</sup> мөн хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд “хөдөө аж ахуйн зориулалттай зээл, маркетингийн байгууламж, зохистой технологи болон газар тариалангийн шинэчлэл, мөн газрын дахин төлөвлөлтийн хуваарь зэрэгт ижил боломж эдлэх” эрхүүдийг баталгаажуулсан билээ.<sup>15</sup>

Хүүхдийн эрхийн тухай Конвенц (ХЭК) нь хүүхэд нэг бүрийн бие махбод, сэтгэл зүй, оюун санаа, ёс суртахууны болон нийгмийн хөгжлийн<sup>16</sup> хувьд зохистой амьдрах стандартыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд оролцогч улсуудад “хангалттай шим тэжээлтэй хоол хүнс болон ундны цэвэр усаар хангах” замаар өвчин болон хоол тэжээлийн дутагдалтай тэмцэхийг үүрэг болгодог.<sup>17</sup>

Үүний адил, ОУХБ-ын 169-р конвенцид нутгийн уугуул иргэдийн хоол хүнсний эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх олон тооны заалтууд бий.

Холбогдох 2-р бүлэгт, (нутгийн уугуул иргэд, овог аймгийн хүмүүсийн нийгэм, соёлын ижилсэл, нийгэм, соёлын эрх болон тэдний ёс заншил, уламжлал, институцыг бүрэн дүүрэн харгалзан үзэх), 2 болон 6-р заалтууд (оролцох болон зөвлөлдөх тухайд), 7-р бүлэг (эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хяналт тавих эрх), 13 болон 17-р бүлэг (нутгийн уугуул иргэдийн газар өмчлөх эрхийг хамгаалах) болон 24-р бүлэг (нийгмийн хамгаалал). Хоол хүнсээр хангагдах эрх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр мөн хамгаалагдсан байдаг.<sup>18</sup>

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ)-ын гишүүний хувьд, Непал улс үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд, хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор ХХААБ-ын сайн дурын удирдамжийг батлахаар болсон байна.<sup>19</sup>



---

<sup>14</sup> 12-р зүйл

<sup>15</sup> 14-р зүйл (2)

<sup>16</sup> 27-р зүйл (1)

<sup>17</sup> 24-р зүйл (2) (с) “Орчны бохирдлын эрсдэл болон аюулыг харгалзан үзэж, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний хүрээнд, үүний дотроос, хэрэглэх боломжтой бэлэн технологийг ашиглах, хангалттай шим тэжээлтэй хоол хүнс, ундны цэвэр усаар хангах замаар өвчин болон хоол тэжээлийн дутагдалтай тэмцэх”.

<sup>18</sup> 1949 оны Женевийн конвенц болон холбогдох бусад протоколуудаас Непалын хувьд хамааралтай нь, хүнсний бүтээгдэхүүн, хүнсний үйлдвэрлэл, ургац, мал, ундны усны хангамж, ундны усны болон усалгааны байгууламжууд зэрэг ард иргэдэд зайлшгүй шаардлагатай объектуудыг устгах, мөн ард иргэдийн өлсгөлөнг байлдааны хэрэгсэл болгон ашиглахыг хориглох зэрэг болно.

<sup>19</sup> Сайн дурын удирдамж, [www.fao.org/3/a-y7937e.pdf](http://www.fao.org/3/a-y7937e.pdf) -с үзэх боломжтой.

# 3. ҮНДСЭН ХУУЛИЙН АМЛАЛТ

2007 оны Непалын Түр Үндсэн Хуульд хүнсний хараат бус байдлын эрхийг хүний суурь эрх хэмээн тунхаглаж, “хуульд заасны дагуу иргэн бүр хүнсний аюулгүй байдлын эрхтэй байх ёстой” гэж заасан.<sup>20</sup> Гэвч тухайн үед засгийн газраас шаардлагатай хууль тогтоомжийг баталж хэрэгжүүлээгүйгээс энэ нь ажил хэрэг болж чадаагүй байна.

2015 оны Непалын Үндсэн хууль нь Түр Үндсэн хуулиас хоол хүнсний аюулгүй байдлын заалтыг өвлөн аваад зогсохгүй, хоол хүнстэй байх, өлсгөлөнгөөс ангид байх эрхийг бүрэн дүүрэн хамгаалсан байдаг. 2015 оны Үндсэн хуулийн 36-р зүйлд (1) Иргэн бүр хоол хүнсээр хангагдах эрхтэй, (2) Иргэн бүр хоол хүнсний хомсдолоос шалтгаалж амь насаа аюулд оруулахаас хамгаалуулах эрхтэй, (3) Иргэн бүр хуульд зааснаар хоол хүнсээр хангагдах эрхтэй гэж заажээ. Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийн нэгэн хэсэг болохын хувьд 35-р зүйлийн 4 дэхь хэсэгт ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламжтай байх эрх нь хоол хүнсээр хангагдах зэрэг хүний эрхийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай чухал хэсэг юм.<sup>21</sup>

Хангалттай хэмжээний хоол хүнстэй байх эрхэд нөлөөлөх хэд хэдэн үндсэн баталгаа бий. Непалын Дээд шүүхээс хоол хүнстэй байх эрх ба нэр төртэй амьдрах эрхийн<sup>22</sup> хамаарлыг хэд хэдэн тохиолдолд хүлээн зөвшөөрч, хүний нэр төртэй амьдрах үндсэн эрхийг онцгой ач холбогдолтой гэж үзсэн.<sup>23</sup> Эмэгтэйчүүд, Далитууд, Мадхэшичууд, Тару омгийнхон зэрэг нутгийн уугуул иргэд, тариачдын адил тэгш эрх эдлэхэд үндэслэн нэр төртэй амьдрах эрхийг хангахын тулд Үндсэн хуулийн 18-р зүйлд зааснаар төрийн зүгээс хууль тогтоомжийн дагуу тодорхой арга хэмжээг авах шаардлагатай байна.<sup>24</sup>

Нийгмийн шударга ёсны нэгэн чухал хэсэг болох Үндсэн хуулийн 42-р зүйлд зааснаар ядуус болон “устах аюулд ороод байгаа бүлгийнхний” хоол хүнсийг багтаасан “тусгай боломж ба ашиг тус” хүртэх эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн тариачин бүр газар тариалан эрхлэн газартай байх эрхтэй гэж заажээ. Түүнчлэн, “уламжлалт байдлаар ашиглаж ирсэн нутгийн үр болон тарианы төрөл зэргийг сонгон хамгаалах” эрх ч хамгаалагдсан байдаг. 38.2-р зүйлд эмэгтэйчүүдийн эрхийг тусгайлан

<sup>20</sup> 18-р зүйл

<sup>21</sup> НҮБ-ын ЕА, тогтоол А/RES/64/292; ЭЗНСЭОУП, 15-р Ерөнхий санал зөвлөмж, Усаар хангагдах эрх

<sup>22</sup> Непалын үндсэн хууль, 16-р зүйлийн 1.

<sup>23</sup> Жишээ нь, хүний нэр төртэй амьдрах эрх ба хоол хүнсээр хангагдах эрхийн харилцан хамаарлыг хүлээн зөвшөөрч, Непалын засгийн газрын эсрэг Пракаш Мани Шарма дахь Дээд шүүх болон олон нийтийг төлөөлж гаргасан нэхэмжлэлд (шүүхийн шийдвэр 2065-w0-149) хэн ч хоол хүнсгүйгээр амьдарч чадахгүй бөгөөд хэрвээ хоол хүнсний хомсдолыг яаралтай шийдвэрлэхгүй бол нөхөж болшгүй хохирол амсч, хугацаа алдвал эмчлэх аргагүй болно гэжээ. Дэлгэрэнгүйг, НҮБ, ХХААБ, Непал дахь хангалттай хэмжээний хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт ба хууль тогтоомжийн асуудлаар хийсэн судалгаанаас үз. 2014 он, 99-108-р хуудас. [www.fao.org/right-to-food/resources/resources-detail/en/c/253864/](http://www.fao.org/right-to-food/resources/resources-detail/en/c/253864/)

<sup>24</sup> Үндсэн хуулийн 18.3 дахь зүйл



баталгаажуулж, эмэгтэй хүн бүрийн “эсэн мэнд амаржих болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах эрх”-ийг тусгажээ. 39-р зүйлд өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, орон гэргүй хүүхдүүд, тухайлан зөрчил мөргөлдөөний болон хүний эрхийн зөрчлийн золиос болсон хүүхдүүдийг “төрөөс тусгайлан хамгаалалт болон орон байраар хангах”<sup>25</sup> эрхийг баталгаажуулжээ. 41-р зүйлд заасны дагуу ахмад настнууд нийгмийн хамгааллын тусгай эрх эдэлнэ.

Түүнчлэн, Удирдах зарчмууд болон тус улсын бодлогын баримт бичгүүдийн хүрээнд олон тооны амлалт (50, 51-р зүйл) өгсөн байдаг. Тэдгээрийн олон нь хоол хүнс болон хүнсний хараат бус байдлын эрхтэй шууд холбогдож байгаа юм.<sup>26</sup>



---

<sup>25</sup> 2015 оны Непалын Үндсэн хууль, 39.9 дүгээр зүйл

<sup>26</sup> Орлогыг шударгаар хуваарилах, эдийн засгийн тэгш бус байдлыг арилгах замаар мөлжлөгөөс ангид нийгмийг байгуулах, хүний аюулгүй байдлын тогтолцоог баталгаажуулах, тариачдын ашиг сонирхлыг харгалзаж үзсэн шинжлэх ухааны үндэслэлтэй газрын шинэтгэл хийх, фермерүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын сацуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ шударга үнээр зах зээлд худалдах боломжийг олгох, найдвартай, тогтвортой усжуулалтын систем нэвтрүүлэх, эх, нялхсын эндэгдлийг бууруулах замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн хамт хүнсний үйлдвэрлэлийг цаг уур, хөрсний байдал, мөн хүнсний хараат бус байдалтай уялдуулан, үйлдвэрлэлийн тогтвортой хангамж, хадгалалт, аюулгүй байдлыг хангах, хялбар, үр дүнтэй түгээлтийн арга замыг бий болгох, хүн бүрийг наад захын хэрэгцээт бараа болон үйлчилгээгээр хангах, мөн алслагдсан, орхигдсон бүс нутагт онцгой анхаарч, төлөвлөгөөтэйгөөр хангамжийн тогтолцоог бий болгох.

# 4. ХУУЛИЙН НЭМЭЛТ ТАЙЛБАР

Хоол хүнстэй байх эрх ба хүнсний тухай хууль нь (цаашид Акт гэх) Непал улсын хоол хүнстэй байх эрхийг бүхэлд нь хамарсан хуулийн цогц бүрдэл хэсэг юм. Уг Акт нь шаардлага хангасан хоол хүнсээр хангагдах эрхийг эдлэх боломжит орчныг бүрдүүлэхэд чиглэсэн олон тооны эерэг заалт багтааснаас гадна, үүгээрээ тус улсын амлалт өгсөн Тогтвортой Хөгжлийн Зорилт (ТХЗ)-уудад (жишээ нь, Зорилт 2: өлсгөлөнг устгах, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний шим тэжээлийг нэмэгдүүлэх болон газар тариалангийн тогтвортой байдлыг дэмжих) хүрэхийг ч мөн эрмэлзэж буй юм.

Непалын иргэний нийгмийн бүлгүүдийн дэмжиж буй хуулийн зарим гол эерэг заалтууд нь ихэвчлэн хоол тэжээлээр дутмаг айл өрхүүдийг тодорхойлохтой холбоотой байна (5 болон 6-р зүйл). Тухайлбал нэн тэргүүнд туслалцаа үзүүлбэл зохих айл өрхүүдэд хоол хүнс түгээх (7-р зүйл), тариаланчдын эрхийг хамгаалах (12-19-р зүйл), хоол хүнсний төлөвлөлт хийх хэрэгцээ шаардлага (20-р зүйл), нийтийг хамарсан хоол хүнсний хэрэгцээ болон түгээлтийн тогтолцоог бий болгох (25-30-р зүйл), зайлшгүй шаардлагатай хоол хүнсний хангамжид саад учруулж буй зарим үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох (39-р зүйл) зэрэг болно.

Эмнести Интернэшнлийн зүгээс Непал улсын засгийн газарт уг Актын талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг нэн даруй авч хэрэгжүүлэх, холбогдох талууд (жишээ нь, хоол хүнсээр хангагдах эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгүүд, тэрхүү бүлгүүдийг төлөөлж буй болон бусад иргэний нийгмийн байгууллагууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд, мөн орон нутгийн болон бүс нутгийн засгийн газруудын холбогдох байгууллагууд)-тай зөвшилцөн, шаардлагатай дүрэм, журмуудыг нэн даруй батлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Ингэснээр Актын заалтуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бий болгох юм.

Үүний сацуу, Актэд нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн тайлбар хийх зэргээр заалтуудыг тодорхой болгох, цаашид улам боловсронгуй болгох иргэний нийгмийн байгууллагуудын хөндөж буй асуудлуудыг мөн Эмнести Интернэшнлийн зүгээс дахин дурдаж байна. Дээр дурдсан үндсэн хуулийн амлалтууд болон олон улсын өмнө хүлээсэн үүргүүдийн хүрээнд дараах санал, зөвлөмжүүдийг өгч байна.

## 4.1 ХУУЛИЙН ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭНД

Хуулийн оршил болон 3-р бүлэг зэргээс харвал иргэдэд чиглэсэн эрх зүйн хамгаалалтын хүрээ нь улам бүр нарийвчлалтай болсон нь илэрхий байна. Олон улсын эрх зүйд хоол хүнстэй байх эрхийн хувьд тухайн улсын иргэний харъяалалтай болон харъяалалгүй хүнд ялгаатай хандахыг зөвшөөрдөггүй.<sup>27</sup> ЭЗНСЭОУП-д дурдсанчлан, өлсгөлөнгөөс ангид байх нь хүний наад захын, үндсэн эрх бөгөөд иргэний харъяалал болон эрх зүйн байдлаас хамааран хязгаарлагдах ёсгүй юм. Эмнести Интернэшнлийн зүгээс өөрийн нутаг дэвсгэрт

<sup>27</sup> ЭЗНСЭХ-ны мэдэгдэл, ЭЗНСЭОУП-ын дагуу дүрвэгчид, цагаачдын талаар төрөөс биелүүлэх үүрэг, НҮБ-ын баримт бичиг, E/C.12/2017/1, 8-9 догол мөр

байгаа бүхий л хүмүүсийн хоол хүнстэй байх үндсэн, наад захын эрхийг хангахын тулд Хуулийн хамрах хүрээг өөрчлөхийг Непалын засгийн газрыг уриалж байна.

#### **Зөвлөмж:**

- *Харьяалалгүй иргэдийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах болон ялангуяа хангалттай хэмжээний хоол хүнсээр хангагдах үндсэн, наад захын эрхийг хангахын тулд Актын хэрэгжилтийн цар хүрээг томруулах*

## **4.2 НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

Тус Актад хэрэглэх нэр томъёо, тодорхойлолт нь тодорхой, оновчтой байх нь үүнийг нэгэн ижил байдлаар хэрэглэх, үр нөлөөтэй хэрэгжилтийг хангах үндэс мөн билээ. Актад хэрэглэгдэж буй зарим тодорхойлолтууд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтуудтай таарахгүй байх буюу зарим гол нэр томъёог орхигдуулсан гэж Эмнести Интернэшнл үзэж байна.

2(b) -р хэсэгт “тариачин” гэж “газар тариалан эрхлэн амьжиргаагаа залгуулдаг, хөдөө аж ахуйн салбарт жилийн 6 сар хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, эсвэл хөдөө аж ахуйн уламжлалт багаж хэрэгслээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувь хүн, мөн түүнээс гэр бүлийн гишүүдийн амжиргаа хамааралтай амьдардаг” хүмүүс хэмээн тодорхойлсон байна. Тариалангийн газаргүй хүмүүсийн хувьд жилд зургаан сар газар тариалан эрхэлнэ гэдэг нь бэрхшээлтэй байж болно. Жишээ нь, эдгээр тариаланчид тариалалт болон ургац хураалтын улиралд фермд ажиллаад, бусад цагт барилгын ажил хийдэг байж болно. Одоогийн тодорхойлолтоор бол, эдгээр ажилчид Хуулийн дагуу тариачдын авах хамгаалалтаас хасагдах эрсдэлтэй юм.

Иймээс Эмнести Интернэшнлийн зүгээс “тариачин” хэмээх тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөхийг уриалж байна. “Тариачин” хэмээх тодорхойлолтыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөний дагуу “амьжиргаагаа залгуулахын тулд эсвэл зах зээлд нэвтрүүлэхийн тулд дангаараа болон бусадтай хамтран, бага хэмжээгээр газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа” мөн “тухайн газраас амьжиргаа нь ихээхэн хамаардаг хүн” гэж өөрчилж болно.<sup>28</sup>

Хүнсний хараат бус байдал болон хүнсний аюулгүй байдлын талаар тусдаа тодорхойлолт бий боловч Актад хоол хүнстэй байх эрхийн талаар бие даасан тодорхойлолтыг тусгаагүй байна.<sup>29</sup> Мөн Актад “өлсөх”,<sup>30</sup>

<sup>28</sup> 2018 оны 12 сарын 18-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас батласан “Тариачид болон хөдөө орон нутагт ажилладаг бусад хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын тунхаглалын 1-р зүйлд заасны дагуу, “тариачин” гэж “дангаараа болон бусадтай хамтран бүлгийн зохион байгуулалтаар, амьжиргаагаа залгуулахын тулд, эсвэл худалдахын тулд бага хэмжээний газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, гэр бүлийн болон өрхийн хөдөлмөр нь мөнгөн бус хэлбэрээр, ямар нэгэн байдлаар газар тариалангийн хөдөмөрт зориулагддаг, газраас амьжиргаа нь ихээхэн хамаардаг хүмүүс” юм. <http://undocs.org/en/A/C/3/73/L.30> -г үз.

<sup>29</sup> ЭЗНСЭОУП-д тодорхойлсноор, “Хоол хүнсээр хангагдах нь эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд бүр дангаараа болон бусадтай хамтран, ямар ч үед хоол хүнсээ хүрэлцээтэй хэмжээгээр авах эдийн засгийн болон бодит боломжтой үед л хэрэгжинэ” (Ерөнхий санал зөвлөмж 12, 6-р догол мөр). Хоол хүнсний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тодорхойлсоноор “хоол хүнсээр хангагдах эрх нь тогтмол, байнгын, шууд, эсвэл санхүүгийн арга хэрэгслээр худалдаж авахад ямар нэгэн хязгаарлалтгүй, тоо болон чанарын хувьд хангалттай, худалдан авагчийн соёлын уламжлалд нийцсэн, хувь хүн, хамт олны бие махбод, оюун санааны хувьд нийцсэн, айдасгүй, сэтгэл хангалуун, нэр төртэй амьдрах боломжийг олгох” учиртай юм. Тусгай илтгэгчийн тайлан, Жан Зиглэр, НҮБ-ын баримт бичгүүд, A/HRC/7/5, 17-р догол мөр.

<sup>30</sup> Өлсөх — олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн тодорхойлолт байхгүй. Гэхдээ, өлбөрч үхэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хамгийн бага илчлэгийг давсан ойлголт гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх болжээ. Өлсөх гэдэг нь, хоол хүнсний ноцтой хомсдол, хувь хүний болон бүлэг хүмүүсийн бие махбодийн болон сэтгэхүйн хувьд хэвийн байлгахад шаардлагатай шим тэжээлийг бүрэлдэхүүн хангалтгүй байх буюу хангалттай хэмжээний хоол хүнсгүй байхыг оролцуулан төрөл бүрийн тэжээлийн дутагдлыг хамруулсан ойлголт юм. Хоол хүнсний эрхийн талаарх нэр томъёог ХХААБ-ын [www.fao.org/right-to-food/resources/glossary/en](http://www.fao.org/right-to-food/resources/glossary/en) хаягаас дэлгэрүүлэн үз.

“өлбөрөх”,<sup>31</sup> “хоол тэжээлийн дутагдал”<sup>32</sup> болон “эмзэг байдал”<sup>33</sup> зэрэг олон чухал нэр томъёоны тодорхойлолтыг тусгаагүй байна. Дээр дурдсанчлан, “өлсөх” болон “эмзэг байдал” зэрэг ойлголтын тодорхойлолтууд байхгүй байгаагаас Актын 3 дахь хэсэгт заасан өлсгөлөнгөөс ангид байх эрх гэж юу болох, мөн өлсөх эрсдэлтэй хүмүүсийг юунд үндэслэн тодорхойлох зэрэгт эргэлзээтэй байдал үүсч болох юм.

#### **Зөвлөмж:**

- *Хоол хүнсээр хангагдах эрх болон тариачин, өлсөх, өлбөрөх, тэжээлийн дутагдал болон эмзэг байдал зэрэг үндсэн чухал ойлголтуудыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтуудтай нийцүүлэн өөрчлөх.*

## **4.3 ХУУЛЬ ЁСНЫ БАТАЛГАА**

Үндсэн хуулийн 36-р зүйлийн агуулгыг нягтлан үзвэл, Актын 3-р хэсэгт хэд хэдэн баталгааг системчлэн оруулсан ба орон нутгийн, бүс нутгийн болон төв засгийн газар тэдгээрийг хүндэтгэх, хамгаалах, сахин биелүүлэх үүрэгтэй хэмээн заажээ. Энэхүү хэсэгт заасан баталгаанд:

чанартай, тэжээллэг хоол хүнсээр тэгш хангагдах, өлсгөлөнгөөс ангид байх эрх ба хоол хүнс дутагдсанаас амь насанд нь аюул учрахаас ангид байх,

өлсгөлөнд нэрвэгдэх болон найдваргүй хүнс хэрэглэх эрсдэлтэй хувь хүн, гэр бүли хоол, тэжээлийн тусламж авах эрх, тариачид газар тариалан эрхлэх газартай байх, тэднийг газар тариалангийн ажлаас нь албадан холдуулахаас хамгаалах зэрэг орно.

Энд тэмдэглүүштэй нэгэн эерэг зүйл бол, Актад тариалан эрхлэгч эмэгтэйчүүд болон тариалан эрхлэх газаргүй өрхүүдэд<sup>34</sup> зориулан тариалан эрхлэх боломжтой газрын хэмжээг нэмэгдүүлэх, мөн албадан нүүлгэхээс хамгаалах амлалтыг оруулсан явдал юм.<sup>35</sup>

Гэвч, Актад уг газрыг хэрхэн эзэмших, мөн төрөөс хэрхэн олгох тухай тодорхой заалт байхгүй (жишээ нь, ашиглах эрх, хянах эрх болон захиран зарцуулах эрх),<sup>36</sup> мөн тухайн газар дээр тариачид, газар тариалангийн ажилчид хэрхэн үйл ажиллагаа явуулах талаар тодорхой заалт байхгүй байна. Мөн Далитын тариачид болон, Тару зэрэг газраас амьжиргаа нь хамаардаг нутгийн уугуул иргэдэд газар тариалан эрхлэх боломжтой газрыг нэн тэргүүнд олгох талаар эрх зүйн ямар нэгэн удирдамж алга байна.

<sup>31</sup> “Өлбөрөх” гэдэг нэр томъёо нь өлсөхийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд удаан хугацаанд үргэлжилсэн, хүнд хэлбэрийн өлсгөлөнгийн улмаас өлбөрч үхдэг, хоол хүнсээр хангагдах эрхийг удаан хугацаагаар зөрчсөний эцсийн нотолгоо юм. ХХААБ-ын [www.fao.org/right-to-food/resources/glossary/en](http://www.fao.org/right-to-food/resources/glossary/en) хаягаас дэлгэрүүлэн үз.

<sup>32</sup> Тодорхойлолт: Хоол тэжээлийн дутагдал нь үндсэндээ “зохисгүй хооллож байна” гэсэн үг. Үүнд хоол тэжээлийн дутагдал, мөн хоол тэжээлийн илүүдэл ч багтана. Энэ нь хоол хүнсний чанар, хэмжээнээс гадна (шаардлага хангасан хоол хүнсгүй байх, эсвэл хэт их хооллох, буруу хооллох) хоолны шим тэжээл биед шингээгүйгээс бие махбод олон төрлийн халдварын хариу урвал үзүүлэх, эсвэл шим тэжээл эрүүл мэндийг тэтгэх чадваргүй байх зэрэг хамаарна. Хүмүүс идэж буй хоолноосоо хангалттай тэжээл авч чадахгүй бол, жишээ нь, суулгалт, эсвэл бусад төрлийн өвчнөөс шалтгаалан тэжээлийн дутагдалд (хоёрдогч тэжээлийн дутагдал) ордог. Хэрвээ хэт их илчлэгтэй хоол хэрэглэдэг (тэжээлийн илүүдэл) бол, эсвэл хоол хүнс нь хүний өсөлт, хөгжилд шаардлагатай илчлэг болон уургийг өгч чадахгүй байгаа бол (тэжээлийн дутагдал ба уургийн дутагдал). Шим тэжээлийн бүх төрлийн дутагдал нь өвчин болон эрт нас баралтын эрсдэлийг нэмэгдүүлдэг. ХХААБ-ын [www.fao.org/right-to-food/resources/glossary/en](http://www.fao.org/right-to-food/resources/glossary/en) хаягаас дэлгэрүүлэн үз.

<sup>33</sup> Эмзэг байдал гэдэгт байгаль орчин, эдийн засаг, нийгмийн эрсдэлүүдээс шалтгаалан, хүнсний хэрэгцээ хязгаарлагдах, эсвэл үндсэн хүнсний хангамжгүй болох нөхцөл байдлыг ойлгоно.

<sup>34</sup> 12-р хэсэг (1)г

<sup>35</sup> 3-р хэсэг (3)к

<sup>36</sup> ХХААБ-ын тайлбараар бол, газрыг эзэмших боломжтой байна гэдэг нь, ерөнхийдөө тухайн газрыг ашиглах явдал юм (тухайн газарт мал бэлчээх, амьжиргаагаа залгуулах хэмжээнд газар тариалан эрхлэх, ойн нөөцийг багхан хэмжээгээр ашиглах гэх мэт), хянах эрх (газрыг хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргах, ургацын борлуулалтаас ашиг хүртэх эрх гэх мэт), захиран зарцуулах эрх (тухайн газрыг худалдах, барьцаалах, бусдад шилжүүлэх болон өв залгамжлуулах, ашиглах болон хянах эрхээ шилжүүлэх эрх). ХХААБ-ын “Газрыг ашиглах боломж гэж юу вэ?”-г үз. [www.fao.org/docrep/005/Y4308E/y4308e04.htm](http://www.fao.org/docrep/005/Y4308E/y4308e04.htm)

3-р хэсэгт төрийн “хүндэтгэх”, “хамгаалах” үүргийг хангалттай тусгаж чадаагүй байна. Төрийн байгууллагын зүгээс иргэдийн өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээхийн тулд гаргаж буй хүчин чармайлтад саад болохыг хориглох (жишээ нь, хоол хүнс, эмээ авахад нь дур зоргоороо хязгаарлалт хийх, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглахболомжтой, ашиглагдаагүй, нийтийн эзэмшлийн газарт тариалан эрхлэхийг хязгаарлах) болон корпорацууд гэх мэт гуравдагч этгээдүүдийг хувь хүн болон бүлгүүдийн хоол хүнсээ чөлөөтэй авах, тэдний хүнсний аюулгүй байдалд аюул учруулахаас хамгаалахшаардлагатай арга хэмжээг авахыг шаардах зэргээрхийж болно.

**Зөвлөмж:**

- *Тариалангийн газрыг эзэмших боломж, нөхцөл, хэлбэрийн талаар тодорхой заалт оруулах (ашиглах эрх, хянах эрх, захиран зарцуулах эрх, түрээслэх болон олон нийтийн эзэмшлийн газрын эрх).*
- *Тариачид, Далит бүлгийнхний эмэгтэй тариачид болон Тару зэрэг тариалангийн газраас амьжиргаа нь хамааралтай байдаг нутгийн уугуул иргэдэд тариалан эрхлэх газрыг нэн тэргүүнд олгох.*
- *Төрийн байгууллагын зүгээс иргэдийн өөрсдийгөө хоол хүнсээр хангах хүчин чармайлтад саад учруулахгүй байх (жишээ нь, ойгоос хүнс болон эмийн ургамал түүх, газар тариалангийн зориулалтаар ашиглах боломжтой, нийтийн өмчийн, ашиглагдаагүй газарт тариалан эрхлэх, загасчлах болон зөгийн бал хураах гэх мэт), гуравдагч этгээдийн зүгээс иргэдийн хоол хүнсээр хангагдах эрхийг зөрчихөөс хамгаалах шаардлагатай арга хэмжээг авахыг шаардах.*

## 4.4 ӨЛБӨРӨХӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ

Актын 4-р хэсэгт өлбөрөхөөс сэргийлэх болон хянах заалт оруулсан нь тэмдэглүүштэй явдал юм. Өлбөрөх эрсдэлтэй хүмүүсийг олж илрүүлэх, бүртгэх, бүртгэлээ тогтмол хөтөлж байхыг төрийн байгууллагуудад Тус актаар үүрэг болгосон байна. Өлсгөлөнгийн нөхцөл байдлыг даван туулахын тулд төрийн зүгээс хүнсний нөөц бий болгох, мөн хүнс түгээх тогтолцоог бий болгох үүрэгтэй. Гэвч төрөөс өлсгөлөнгийн нөхцөлд амьдарч байгаа болон өлбөрөх эрсдэлтэй байгаа хүмүүс, айл өрх, бүлгүүдийг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах талаар Актад тодорхой заагаагүй байна. Түүнчлэн, хүнсний хангамж, хүнс түгээх сүлжээг бий болгохоос гадна Актад хүмүүсийг өлбөрөхөөс нэн даруй хамгаалах тодорхой үйл ажиллагааг (өдөрт хоёр удаа үнэгүй хоол өгөх гэх мэт) тусгах шаардлагатай.

Акт дахь “өлсгөлөнг хянах” хэмээх ойлголт нь өлсгөлөнгөөс урьдчилан сэргийлэх нь төрийн үнэмлэхүй үүрэг бөгөөд өлсгөлөнгөөс ангид байх баталгаа мэтээр тусгасан нь учир дутагдалтай гэдгийг Эмнести Интернэшнл онцолж байна.<sup>37</sup>

Өлбөрч нас барсан хүмүүсийн талаар мөрдөн шалгахгүй байгаа нь өлсгөлөнгөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй төрийн албан хаагчдыг хариуцлагаас зайлсхийх боломжийг олгож байна. Непалын Дээд шүүхийн тогтоолын<sup>38</sup> дагуу өлбөрч нас барсан хүн бүрийн өмнө төр хариуцлага хүлээх ёстой бөгөөд Актад хариуцлага хүлээх талаар тодорхой заалт оруулах нь зүйтэй.

**Зөвлөмж:**

- *Өлсөж буй болон өлбөрөх эрсдэлтэй байгаа хүмүүсийг хамгаалахын тулд хоол тэжээлийн яаралтай тусламжийг (өдөрт хоёр удаа үнэгүй хоол өгөх гэх мэт) зүүлэх тухай заалтыг нэмж оруулах*

<sup>37</sup> ЭЗНСЭОУП, 11-р зүйл, ЭЗНСЭХ-ны 12-р Ерөнхий санал зөвлөмж

<sup>38</sup> Пракаш Мани Шарма нарын Непалын засгий газрын эсрэг нэхэмжилсэн хэрэг, (шүүхийн шийдвэр No.2065-w0-149)



- *Өлбөрч амь насаа алдсан тохиолдол бүрийн талаар мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх үүргээ зөрчсөн (эрүүгийн болон эрүүгийн бус) тохиолдолд хариуцлага хүлээлгэх заалтыг 4-р хэсэгт нэмж оруулах*

## 4.5 ТУСЛАЛЦАА ДЭМЖЛЭГ ШААРДЛАГАТАЙ ӨРХҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ХҮНСНИЙ ТУСЛАМЖ

Актын 5-р хэсэгт “хот, хөдөөгийн ядуурал, газарзүйн алслагдмал байдал, байгалийн гамшиг болон бусад шалтгаанаас үүдэлтэй” хүнсний хангамжийн эрсдэлд эмзэг айл өрхүүдийг тодорхойлох үүргийг Непалын засгийн газарт өгсөн байна. 7-р хэсэгт, хүнсний тусламжийг туслалцаа дэмжлэг шаардлагатай өрхүүдэд хөнгөлттэй үнээр, тусгай бүлэгт хамаарах өрхүүдэд үнэ төлбөргүй олгохоор заасан байдаг.

Гэвч, Актад “үнэ төлбөргүй туслалцаа авах” өрхүүдийг хэрхэн тодорхойлох талаар тодорхой шалгуур үзүүлэлтийг тусгаж өгөөгүй байна. Түүнчлэн, ямар төрлийн, ямар хэмжээтэй хоол хүнсийг туслалцаа болгон өгөхийг тодорхойлоогүй. Орон нутгийн засаг захиргаа хүнс түгээх ажлыг хариуцна гэж Актад заасан ч шат, шатны засаг захиргааны зүгээс иймэрхүү тусламжийг хэрхэн үзүүлэх талаар тодорхой заалт алга байна.

7(2) -р хэсэгт нь онцгой байдлын үед үзүүлэх хүнсний тусламжийн талаар тодорхой бус ойлголтыг тусгажээ. Аливаа байгалын гамшигийн үед хоол хүнсний талаар онцгой байдал зарлаагүй үед ч, хувь хүн, айл өрхүүд, нийгмийн бүлгүүд хоол хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орж, хоол тэжээлийн туслалцаа авах шаардлагатай болсон байж мэднэ. Туслалцаа дэмжлэг шаардлагатай хүмүүсийг хоол хүнс, орон байраар хангах нь төрийн үүрэг гэдгийг Непалын Дээд шүүхээс хэдийнээ тодорхойлсон билээ.<sup>39</sup>

9 (1) болон 10 (1) дахь хэсгүүдэд хүнстэй холбоотой онцгой байдлыг газар хөдлөлт, үер, хөрсний нуралт, цасан шуурга, хүчтэй салхи болон гал түймэр зэрэг байгалын гамшгаар хязгаарласан нь мөн төвөгтэй байдал үүсгэж байна. Албадан нүүлгэн шилжүүлэх, үнийн гэнэтийн өсөлт, авилга болон хүнс түгээлтийн тогтолцоо нуран унах зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй онцгой байдлын үед авах арга хэмжээ Актад байдаггүй.

Түүнчлэн, Акт нь өмнө нь хоол тэжээлийн туслалцаа үзүүлдэг байсан хэд хэдэн хөтөлбөрийг боловсронгуй болгож чадаагүй байна. Иймэрхүү хөтөлбөрүүдэд Үдийн хоол,<sup>40</sup> хөнгөлттэй үнээр хүнс тараах<sup>41</sup> болон Голден 1000 өдрийн хоол тэжээлийн хөтөлбөр<sup>42</sup> зэрэг багтдаг.

### **Зөвлөмж:**

- *“Үнэ төлбөргүй хүнсний туслалцаа авах” өрхүүдийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгох,*
- *Тусалцаа дэмжлэг шаардлагатай өрхүүдэд олгох хүнсний тусламжийн хэлбэр, хэмжээг Акт тогтоомжид тодорхой тусгаж өгөх,*
- *Ямар ч шалтгаанаас үл хамааран өлсгөлөнд хүргэж болзошгүй, хүнсний хомсдолд байгаа хүмүүст хүнсний тусламж үзүүлэх үүргийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосон заалтыг нэмж оруулах,*
- *Хүнстэй холбоотой онцгой байдлыг дахин тодорхойлохдоо хүний үйл*

<sup>39</sup> Ражу Прасад Чапагай нарын Непалын засгийн газрын эсрэг нэхэмжилсэн хэрэг, шүүхийн шийдвэр No.071-wo-0257, Шийдвэр – 2016 оны 6 сарын 8.

<sup>40</sup> Сургууль завсардалтаас сэргийлэхийн тулд сурагчдыг татах зорилготой хөтөлбөр.

<sup>41</sup> Хоол хүнсээр хангагдаж чаддаггүй дүүргүүдэд хүнс тараах зорилготой хөтөлбөр.

<sup>42</sup> Жирэмсэн, хөхүүл эхчүүд болон нярай хүүхдийн хүнс тэжээл, эрүүл мэндийг сайжруулах замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилготой хөтөлбөр.

ажиллагаанаас үүдэлтэй онцгой байдлыг нэмж оруулах,

- Хуулийн хэрэгжих хүрээнд өмнө нь хэрэгжиж байсан олон тооны хүнсний тусламжийн хөтөлбөрүүдийг багтаан, Хуулийн заалтуудтай уялдуулах.

## 4.6 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ НЬ

Актад хоол хүнсээр хангагдах эрхтэй холбогдуулан эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх хэд хэдэн заалт орсон ба оролцоог хангахад нээлттэй хандсан байдаг. Жишээ нь, Актад заасны дагуу “тусламж дэмжлэг шаардлагатай өрхийг таних үнэмлэх”-ийг тухайн өрхөд насанд хүрсэн эмэгтэй хүн байгаа л бол олгодог. Гэхдээ жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд шууд чиглэсэн хүнс тэжээлийн бусад арга хэмжээг Актад тусгаагүй. Хүнс түгээлтийн сүлжээг ажиллуулахдаа Шударга үнийн дэлгүүр болон олон нийтийн хүнс түгээх төвүүдийг ажиллуулах давуу эрхийг эмэгтэйчүүдийн бүлгүүд, эсвэл хөдөө аж ахуйн хоршоодод олгох хэрэгтэй. Гэвч хуулийн хүрээнд хэрэгжүүлэх аливаа төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ жендэрийн асуудлыг хэрхэн тусгах талаар эрх зүйн ямар нэгэн удирдамж байхгүй байна.

### Зөвлөмж:

- Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг хүнс тэжээлээр хангах заалтыг нэмж оруулах
- Хуулийн хүрээнд аливаа шийдвэр гаргах, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхдээ жендэрийн болон нийгмийн оролцоог суурь зарчмуудын нэг болгон нэн тэргүүнд авч үзэх.

## 4.7 ТАРИАЧДЫН ЭРХ

Актын 12, 13-р хэсэгт хөдөө аж ахуйн ажил мэргэжлийг хамгаалах, тариачдын амьжиргааг дэмжих заалтууд тусгагдсан байна. Мөн тариачдын амьжиргааны түвшин, нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр олон арга хэмжээ авахыг тусгажээ. Эдгээр арга хэмжээнд: хөдөө аж ахуйн зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, органик тариалалт эрхлэхэд шаардлагатай аргачлалуудыг боломжтой болгох, генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний сөрөг нөлөөллөөс хамгаалуулах, ган гачгийн үед эрт зарлан мэдээлэх системийг хөгжүүлэх, тогтвортой хөдөө аж ахуйн тогтолцоог хөгжүүлэх, газар тариалангаас амьжиргаа нь хамааралтай эмэгтэй тариачид болон тариалан эрхлэх газаргүй айл өрхүүдэд тариалан эрхлэх газар, хөдөө аж ахуйн ашиг шимээс хүртэх боломжийг нэмэгдүүлэх, мөн тухайн журамд заасны дагуу тариачдад газар тариалангийн үйлдвэрлэлээс хүлээх алдагдлыг нөхөн төлөх зохицуулалт зэрэг болно.

Актад тариачдыг тодорхойлох болон ангилах талаар тусгасан. Орон нутгийн засаг захиргаанаас ялгах үнэмлэхийг олгох үүрэгтэй. Актад тариачдыг ангилж үзээгүй хэдий ч Непалын засгийн газраас тэднийг татаас авдаг, хөнгөлөлт эдэлдэг, мөн туслалцаа авдаг гэж ангилан үздэг. Гэвч жижиг аж ахуй эрхлэгчид, эмэгтэй тариачид, хуучин боолуудад татаас, хөнгөлөлт, туслалцаа авах зэргээр давуу эрх олгох тухай заалт Актад байхгүй. Хуучин Камаяачууд болон хуучин Камаларисчууд зэрэг бүлгийн хүмүүс туслалцаа дэмжлэг авч чадахгүй байгаа нь, зарим тохиолдолд, хүчээр хөдөлмөр эрхэлдэг байсан хуучин байдалдаа ороход хүргэж байна.

Төв, бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргаа нь Далит болон “устах аюулд ороод байгаа” нутгийн уугуул иргэдийг хамгаалах, тэдний сайн сайхны төлөө газар тариалангийн зорилтот хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг Актаар хүлээлгэжээ. Гэвч энэ мэт хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхийн тулд тэдэнд мэдээлэл өгч, оролцоог нь хангах талаар тодорхой шаардлагыг тусгаж өгөөгүй байна. Түүнчлэн, энэ

мэт зорилтот хөтөлбөрт хамрагдахын тулд “устах аюулд орсон” гэдэг шалгуур тавих нь хэтийдсэн хэрэг юм. Оролцоог хангах нь Актаар хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний хараат бус байдлын салшгүй нэгэн хэсэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Цаашилбал, Актад анчид, түүвэрчид болон ой, усны нөөцөөс хоол хүнсээ залгуулж буй бусад бүлгийнхний асуудлыг (жишээ нь Акт, журмын дагуу ой болон дархан цаазтай газарт ой, усны нөөцийг ашиглахыг хязгаарласан заалтууд гэх мэт) шийдвэрлэх тодорхой заалтууд байдаггүй. Нутгийн уугуул иргэдийн чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөлгүйгээр тэдний газар нутаг дээр байгуулсан дархан цаазат газар болон тусгай хамгаалалттай газраас нүүлгэн шилжүүлэх, зайлуулах ёсгүй бөгөөд энэ нь амьжиргаагаа алдах, хүнсний хомсдолд хүргэж болохыг анхаарвал зохино.<sup>43</sup>

#### **Зөвлөмж:**

- *Жижиг аж ахуй эрхлэгчид, эмэгтэй тариачид, хуучин боолуудад татаас, хөнгөлөлт болон усалгаанд хэрэглэх ус, бордоо, бусад төрлийн тусалцаа авах боломжийг нэн тэргүүнд олгох заалтыг нэмж оруулах,*
- *Хөгжлийн, сайн сайхан амьдрал болон нэр төртэй байдлын ялгаатай байдлыг арилгахын тулд Далит болон нутгийн уугуул иргэдийг хамгаалах, тэдний сайн сайхны тулд хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг шаардсан заалтыг Актад нэмж тусгах,*
- *Гадуурхагдсан болон эмзэг бүлгийн тариачдад нөлөөтэй хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ тэдний мэдээлэлд суурилсан оролцоог хангах заалтыг Актад нэмж оруулах,*
- *Анчид, түүвэрчид болон ойгоос хоол хүнсээ залгуулдаг иргэдийн эрхийг хүлээн зөвшөөрч, тэдний хоол хүнстэй байх эрх, хүнсний аюулгүй байдалд нийцсэн тусгай хөтөлбөр боловсруулах тухай заалтыг Актад нэмж оруулах,*
- *Нутгийн уугуул иргэдийн газар нутаг дээр дархан цаазат газар болон тусгай хамгаалалттай газар байгуулах санал гарсан бол тэдний чөлөөт, урьдчилсан, мэдээлэлд суурилсан зөвшөөрлийг авдаг байх, мөн тэрхүү саналын үр дүнд тэднийг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд тэдний анхны эрхийг нь сэргээх, эсвэл нөхөн төлбөр олгох эрхийг нь баталгаажуулсан заалтыг Актад нэмж тусгах.*

## **4.8 ТАРИАЛАН ЭРХЛЭХ ГАЗРЫН ТОГТВОРТОЙ АШИГЛАЛТ**

15-р хэсэгт зааснаар, төрийн бүх шатны засаг захиргааны зүгээс хоршооллийн, түрээсийн, гэрээлсэн болон хамтарсан аж ахуй эрхлэгчдийг дэмжин үржил шимгүй газрыг тултал нь ашиглаж тогтвортой тариаланг хөгжүүлэхийг шаарддаг.

Гэвч хоршоолол, түрээсийн, гэрээлсэн болон хамтарсан аж ахуй эрхлэх байгууламжийн хувьд газаргүй, гэр оронгүй айл өрхүүд, Далит, нутгийн уугуул иргэд болон газраас амьжиргаа нь шалтгаалдаг гадуурхагдсан өрхүүдийг нэн тэргүүнд авч үзэх асуудлыг Актад орхигдуулсан байна.

Засгийн газрын зүгээс хоршоолол, хамтарсан аж ахуйн газрын тогтвортой ашиглалтыг дэмжихдээ тариалан эрхлэх газаргүй иргэд, Далит, нутгийн уугуул иргэд болон газраас амьжиргаа нь хамаардаг өрх толгойлсон эмэгтэйчүүдийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэхийг Эмнести Интернэшнл уриалж байна.

<sup>43</sup> НҮБ-ын Нутгийн уугуул иргэдийн эрхийн талаарх Хүний эрхийн зөвлөлийн Тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ын баримт бичгүүд, А/71/229, 28, 51-р догол мөр, Читван орчмын хамгаалалтын бүсэд амьдардаг нутгийн уугуул иргэд хэрхэн эрхээ зөрчүүлсэн тухай баримтыг дэлгэсэн BuzzFeed News-ийн мөрдөн байцаах ажиллагааны тайланг үз. [www.buzzfeednews.com/article/tomwarren/wwwf-world-wide-fund-nature-parks-torture-death](http://www.buzzfeednews.com/article/tomwarren/wwwf-world-wide-fund-nature-parks-torture-death)

Зөвлөмж:

- 14-р хэсэгт заасан байгууламжийн хувьд газаргүй, орон гэргүй айл өрхүүд, Далит хүмүүс, нутгийн уугуул иргэд, газраас амьжиргаа нь хамаардаг өрх толгойлсон эмэгтэйчүүд мөн гадуурхагдсан айл өрхүүдийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх заалтыг нэмж оруулах

## 4.9 ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Хоол хүнстэй байх эрх, хүнсний хараат бус байдалтай холбоотой асуудлыг Актад төлөвлөгөөтэйгөөр авч үзэж байгаа хандлагыг Эмнести Интернэшнл сайшааж байна. Актын 21-р хэсэгт, хоол тэжээлийн үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшил, төрийн болон төрийн бус оролцогч талуудтай зөвшилцөж боловсруулах шаардлагыг тавьсан байдаг. Мөн засгийн газрын хөгжлийн үе шаттай хөтөлбөрүүдэд ч хоол хүнстэй байх эрх, хүнс тэжээлийн аюулгүй байдал, хүнсний хараат бус байдлын эрхийн асуудлуудыг тусгасан байхыг шаарддаг.

Гэвч, хоол тэжээлийн үндэсний хөтөлбөрт тусгавал зохих асуудлуудыг Актад нарийн тодорхойлж оруулаагүй байна. Хөтөлбөрийг амжилттай боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай хэд хэдэн асуудал (жишээ нь, өлсгөлөн болон тэжээлийн дутагдлаас сэргийлэх, хоол тэжээлтэй байх боломж, хөдөө аж ахуйг дэмжих, газар тариалангийн үр шимийг тариачид хүртэх боломж, хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоонд жендэрийн болон нийгмийн оролцоог хангах, үр нөөцлөх асуудал, хөдөө аж ахуйд уур амьсгалын өөрчлөлт нөлөөлөх нь)-ыг хөтөлбөрийг боловсруулах шатанд нэн тэргүүнд авч үзвэл зохино.

Хүнсний асуудал хариуцсан зөвлөл болон холбогдох бусад байгууллагуудтай зөвшилцөж, хоол хүнстэй байх эрхийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүдийг батлах тухай мөн Актад тусгасан. Гэвч ХЭҮК-ын зүгээс хоол хүнстэй байх эрхийн хэрэгжилтийг хянах хэд хэдэн суурь шалгуур үзүүлэлтийг боловсруулахаар аль хэдийн ажилласан тул оролцогчдын тоог нэмэгдүүлэх боломжийг хязгаарласан байна.<sup>44</sup>

Зөвлөмж:

- Хоол тэжээлийн үндэсний хөтөлбөрт нэн тэргүүнд тусгавал зохих асуудлуудын жагсаалтыг гаргах
- Хоол хүнстэй байх эрхийн хэрэгжилтийг хянахын тулд шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эргэн хянах чиглэлээр судалгааны болон иргэний нийгмийн байгууллагууд, Үндэсний хүний эрхийн байгууллагуудтай зөвлөлдөх боломжийг хангах.

OHCHR.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>44</sup> НҮБ-ын ХЭДКГ- Непал, ХЭҮК, Непал дахь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүд: Хэрэглэгчийн гарын авлага, <http://nepal.ohchr.org/en/resources/publications/2011/Indicators%20for%20Monitoring%20ESCR%20in%20Nepal-%20A%20User's%20Guide.pdf>

## 4.10. ҮНДЭСНИЙ, БҮС НУТГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ ЗАСГИЙН ГАЗРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Актын олон хэсэгт (7, 9, 12, 13, 18 болон 30 дугаар хэсэгт) хоол хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн олон тооны арга хэмжээг төв, бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагаагаар шийдвэрлэх талаар заасан байдаг. Үндсэн баримтлах зарчим болохын хувьд, төв, бүс нутаг, орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааны уялдаа холбооны талаарх зөвлөмж ойлгомжтой байна.<sup>45</sup> Гэвч хүнсний тусламж хуваарилах замаар хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх болоход бүх шатны засаг захиргааны Акт, журмын дагуу биелүүлбэл зохих үүрэг хариуцлага нь маш тодорхой байх шаардлагатай.

### Зөвлөмж:

- Төв, бүс нутаг, орон нутгийн засаг захиргааны Актыг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон нэмэлт өөрчлөлтүүдийг хийх


## 4.11. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА БА ХӨГЖИЛ

Актын 25-р хэсэгт хүнсний салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжлийн талаар тусгасан байдаг. Төрийн бүх шатны засаг захиргаа хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хоол тэжээлийн аюулгүй байдлын талаар судалгаа шинжилгээ хийх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бүрэн эрхтэй. Энэ нь төрөөс иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд болон бусад талуудтай хамтран ажиллах үүд хаалгыг нээж өгч байгаа юм.

Акт, журмын дагуу иж бүрэн үүрэг хүлээлгэсэн тул, төрийн бүх шатны удирдлага төсөв хуваарилах, гадны эх үүсвэрийг ашиглах болон Актад заасан зорилгыг биелүүлэхийн тулд судалгаа хийх зэргээр нээлттэй ажиллах боломжтой.

### Зөвлөмж:

- 25-р хэсэгт заасан судалгаа шинжилгээг явуулахдаа тариалан эрхлэх газаргүй, хуучин Камайя болон Камаларичууд, Халиаячууд, Далитууд, нутгийн уугуул иргэд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, хот болон хөдөөгийн ядуусын хүнсний аюулгүй байдалд үнэлгээ хийх асуудлыг нэн тэргүүнд тавибал зохино.



## 4.12. ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Актын 29-р хэсэгт хүнсний гол нэрийн, үндсэн бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахыг Непалын засгийн газарт үүрэг болгосныг тэмдэглэх хэрэгтэй. Хоол хүнсээ боломжийн үнээр авах боломжийг олгосон энэхүү заалтыг нэн даруй хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэвч Актад төрийн зүгээс үнийн тогтвортой байдлыг хангахад (үнэ тодорхойлох, үнэд шинжилгээ хийх, хяналт тавих гэх мэт) удирдамж болох ямар ч заалт байхгүй.

<sup>45</sup> Непалын Үндсэн хууль, 56-р зүйл



Энэхүү чиг үүргийг биелүүлэх төрийн тусгайлсан байгууллагыг Актад тодорхойлоогүй болно. Түүнчлэн, энэ чиглэлээр бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргаа ямар үүрэг гүйцэтгэхийг ч тусгаагүй.

**Зөвлөмж:**

- *Актад нэмэлт өөрчлөлт оруулах болон Актыг хэрэгжүүлэх хүрээнд гарах журамд үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргааны хүлээх үүргийг нарийвчлан тусгаж өгөх*

## 4.13 ЗОХИЦУУЛАХ МЕХАНИЗМ

Үндсэн хууль болон бусад хууль дахь эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрхээ эдлэх хамгийн эхний алхам юм. Хоол хүнсээр хангагдах эрх болон хүнсний аюулгүй байдлын үүднээс хараат бус зөвлөл гэх мэт бие даасан агентлаг ажиллах нь энэ Акт, бусад хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Актад (32, 34 болон 36-р хэсэг) хэдийгээр ийм механизмыг (үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд ажиллах хоол хүнсний асуудал хариуцсан зөвлөл) бий болгохоор заасан боловч хэрхэн бий болгох талаар болон бүрэн эрхийг нь тусгаж өгөөгүй. Эдгээр асуудлыг холбогдох төрийн байгууллагын шийдэх асуудлын хүрээнд үлдээсэн байна.


Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч болон ЭЗНСЭХ-ны аль аль нь Актын хэрэгжилтэнд хяналт тавих бие даасан, хүчирхэг механизм чухал болохыг онцлон тэмдэглэсэн байдаг.<sup>46</sup>

**Зөвлөмж:**

- *Хоол хүнсний асуудлыг зохицуулах үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн зөвлөлүүдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүрэн эрх болон үүрэг хариуцлагыг Актад тодорхой болгон нэмж оруулах*

## 4.14. ГЭМТ ХЭРЭГ БА ЯЛ ШИЙТГЭЛ

Холбогдох хуулийн 40-р хэсэгт хүнсээр хангагдах боломжийг хязгаарласан, улмаар хоол хүнсстэй байх эрхийг зөрчсөн тодорхой үйлдлүүдийг<sup>47</sup> гэмт хэрэгт тооцдог. Хуулийн 44-р хэсэгт хориглосон үйлдлүүдийг мөрдөн шалгах ажилтнуудыг томилох эрхийг засгийн газарт олгосон байдаг. Энэхүү заалтад, эдгээр мөрдөн шалгах ажилтнууд хангалттай сургаж бэлтгэгдсэн, шударга шүүх ажиллагаанд баталгаа өгч чадахуйц, мөрдөн шалгах ажиллагааг журмын дагуу зохистой явуулах чадвартай байх шаардлагыг тусгаж өгөөгүй.



<sup>46</sup> Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн цохон тэмдэглэсэнээр, төрийн холбогдох яамд, байгууллагууд, иргэний нийгэм, хүнс үйлдвэрлэгчдийн холбоо болон хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс бүрдсэн хараат бус зөвлөлийг байгуулах замаар хүнс тэжээлийн аюулгүй байдлын асуудлаар засгийн газарт зөвлөгөө өгдөг уялдаа холбоо бүхий, нэгдсэн арга барилыг бий болгох нь чухал юм. Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тайлан, Малави дахь томилолт, НҮБ-ын бичиг баримтууд, A/HRC/25/57/Add.1. ЭЗНСЭХ, Ерөнхий санал зөвлөмж 12, Хангалттай хэмжээний хоол хүнсээр хангагдах эрх (11-р зүйл) E/C.12/1999/5.

<sup>47</sup> Актад заасан гэмт хэрэгт "хүний нэн шаардлагатай хоол хүнсээ авах боломжид саад учруулах, ингэснээр ноцтой үр дагаварт хүрэх, эсвэл өлсгөлөнгийн нөхцөл байдал бий болгох, онцгой байдлын үед тусламж үзүүлэх зорилгоор нөөцөлсөн хоол хүнсэнд хяналтаа тогтоох, зүй бусаар ашиглах болон устгах, онцгой байдлын үед хүнсний тусламж түгээхэд саад учруулах, хүнсний үндсэн нэрийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, нийлүүлэх, түгээх, борлуулахад санаатай болон санамсаргүй байдлаар саад учруулах, хэн нэгнийг орон гэргүй болгосноор амьжиргаанаас нь салгах, зорилтот болон туслалцаа дэмжлэг шаардлагатай бүлгийнхэнд хүнсний тусламж үзүүлэхээс татгалзах" зэрэг болно.

40-р хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон хүнд 41(2) хэсэгт заасны дагуу 35 хоногийн дотор ял оногдуулна. Энэ нь гэмт хэргийн онц ноцтой байдал болон Непал улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдалтай (газар нутгийн алслагдсан байдал, боловсрол, жендэрийн болон угсаатны ялгаатай байдал, эрх зүйн мэдлэг дутмаг гэх мэт) тохирохгүй байна.

**Зөвлөмж:**

- *Мөрдөн шалгах ажилтнууд шударга шүүх ажиллагаанд баталгаа өгч чадах, мөрдөн шалгах ажиллагааг журмын дагуу зохистой явуулах чадвартай, хангалттай сургаж бэлтгэгдсэн байх шаардлагыг Актад нэмж тусгах,*
- *Гэмт хэргийн ноцтой байдал, тус улсын нийгэм, эдийн засаг, газар зүйн нөхцөл байдалтай уялдуулан хуулийн зохицуулалтыг хийх.*

## 4.15. НӨХӨН ОЛГОВОР

20-р хэсэгт ургац алдсан үед нөхөн олговор олгохоор заасан бөгөөд Дээд шүүхийн зарчимд нийцэж байна.<sup>48</sup> Гэвч нэхэмжлэлийг шалгаж үзэх, хохирлыг үнэлэх болон зохистой нөхөн олговрын механизмыг тодорхойлж өгөөгүй.

43-р хэсэгт мөн тус Актын хүрээнд гаргасан ямар ч гомдлын хохирлыг нөхөн төлөхөөр тусгажээ. Гэвч энэ заалтад нөхөн олговрын шалгуур үзүүлэлт болон стандартыг нарийвчлан тусгаагүй, харин ч засгийн газрын шийдэх асуудлын хүрээнд үлдээсэн байна.

**Зөвлөмж:**

- *Ургац алдсанаас учирсан хохирлыг судлах, үнэлэх болон нөхөн олговор олгох механизмыг нарийвчилан тусгасан өөрчлөлт Актад оруулах,*
- *Нөхөн олговрыг тооцоолоход хэрэглэгдэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгон, Актад нэмэлт өөрчлөлт оруулах,*
- *Хохирсон айл өрхүүд, орон нутгийн бүлгүүдэд зориулсан хамтарсан болон ганцаарчилсан нөхөн олговрын бусад хэлбэрүүдтэй (татаас, хөнгөлттэй зээл, бичил зээл болон бусад дэмжих арга хэмжээ гэх мэт) уялдуулах.*

## 4.16. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах механизмыг эс тооцвол, тухайн эрх эзэмшигч болон оролцогч талууд үүргээ гүйцэтгээгүй гэж, эсвэл хуулийн дагуу эрх олгоогүй байна гэж үзвэл гомдлыг зохицуулах механизмыг Актад зааж өгөөгүй байна. Энэ нь бие даасан, захиргааны гомдлын механизм байж болох бөгөөд нэхэмжлэгчийн гомдлыг хурдан шийдвэрлэх, мөн шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнө барагдуулах боломжтой. Гомдол шийдвэрлэх ийм ажилтнуудыг ил тод үйл явцын дагуу томилох хэрэгтэй. ХЭҮК-оос хуулийн хэрэгжилтэнд нь хяналт тавих эрх олгосон, бүх шатны засаг захиргааг зөвлөмжөөр хангадаг хялбаршуулсан шүүхийн механизм байж болох юм.

**Зөвлөмж:**

- *Эрх эзэмшигчид болон бусад оролцогч талууд үүргээ биелүүлээгүй, хуулийн дагуу эрх олгоогүй байна гэж, эсвэл Акт хэрэглэхдээ ялгаварлан гадуурхсан гэж үзвэл маргааныг шийдвэрлэх үүрэг бүхий тусдаа захиргааны, эсвэл хялбаршуулсан шүүхийн механизмыг бий болгох тухай заалтыг Актад нэмж оруулах.*

<sup>48</sup> Бажуддин Минхья бусад, Непалын засгийн газрын эсрэг гаргасан нэхэмжлэл, ЕС болон Сайд нарын зөвлөл, (Кошу Таппу дахь дархан цаазат газрын зэрлэг амьтад ургац сүйтгэсэн тухай хэрэг), (шүүхийн шийдвэр No.WO-0338) 2008, (2064 BS), 2009 оны 3 сарын 18-ны өдрийн шийдвэр.

# 5. ДҮГНЭЛТ

Хоол хүнсээр хангагдах эрх, хүнсний аюулгүй байдлын тухай Актыг (2018) баталсан явдал нь хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтэнд чухал алхам болсон юм. Актад найдвартай хоол хүнсээр хангагдаж чаддаггүй айл өрхүүд, тариачдын эрхийг хамгаалах, хоол хүнсээр хангах төлөвлөлт хийх, наад захын үндсэн хүнсээр хангагдах боломжид саад учруулсан тохиолдолд авах шийтгэлийн арга хэмжээг тодорхойлж өгсөн зэрэг олон чухал заалтууд орсон байдаг. Эдгээр заалтыг хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, шаардлагатай дүрэм, журмууд болон хоол хүнсний асуудлаарх үндэсний хөтөлбөрийг оролцогч талуудтай зөвшилцөн боловсруулах хэрэгтэй.

Актын заалтуудыг Непалын Үндсэн Хууль болон тус улсын олон улсын өмнө хүний эрхийн асуудлаар хүлээсэн үүргүүдийн хүрээнд үнэлж үзэхэд, Эмнести Интернэшнлийн зүгээс, нэр томъёо болон эрх үүрэг, хэрэгжилтийн механизмтай холбоотой олон тооны хийдлийг олж харсан бөгөөд эдгээрийг Актад нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой юм. Эдгээр хийдлийн олонхийг цогц Акт тогтоомж батлах замаар засах боломж мөн бий. Дараах нэр томъёог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтод нийцүүлж чадвал эрх зүйн орчныг бэхжүүлэх юм. Үүнд, а) “хоол хүнсгүй байх эрх”, “тариачин”, “өлсөх”, “өлбөрөх”, “тэжээлийн дутагдал” болон “эмзэг байдал”, b) өлбөрч байгаа гэж тодорхойлогдсон хүмүүсийг хамгаалахын тулд нэн яаралтай хүнс, тэжээлийн туслалцаа үзүүлэх, c) өлбөрч нас барсан тохиолдол бүрийг зайлшгүй хянан шалгах, d) нэн тэргүүнд туслалцаа үзүүлэх шаардлагатай айл өрхөд олгох хүнсний тусламжийн хэлбэр хэмжээг тодорхойлох, e) Далит бүлгийн тариачид, эмэгтэй тариачид болон Тару зэрэг газраас амьжиргаа нь хамаардаг нутгийн уугуул иргэдэд тариалан эрхлэх газрыг нэн тэргүүнд олгох талаар тодорхой удирдамж гаргах, нөхцөл болон хэлбэрийг нь мөн хавсаргаж өгөх, f) Стандартыг тогтоох, хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлаар засгийн газарт зөвлөх эрхтэй мэргэжлийн байгууллага байгуулах, g) хоол хүнсээр хангагдах баталгааг олгож байгаа хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад нутгийн уугуул иргэдийн оролцоог хангах шаардлагатай.

СИ.МН  
СУДАЛГААНЫ САН

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# НЕПАЛ УЛС ДАХЬ ХООЛ ХҮНСТЭЙ БАЙХ

## ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### 2018 ОН: ХООЛ ХҮНСТЭЙ БАЙХ ЭРХ БА ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмнести Интернэшнлээс 2018 оны Непал улсын Хоол хүнстэй байх эрх болон Хүнсний тухай хуулинд Үндсэн хуулийн болон ЭЗНСЭОУП-ыг оролцуулан тус улсын олон улсын өмнө хүлээсэн эрх зүйн үүрэг хариуцлагын хүрээнд үнэлгээ хийлээ. Уг үнэлгээнд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тодорхой, цогц зөвлөмжүүдийг санал болгосноос гадна Актад тусгагдсан эерэг заалтуудыг цаг алдалгүй хэрэгжүүлэхийг сануулсан байна. Эмнести Интернэшнлийн зүгээс хоол хүнстэй байх эрх нь зөрчигдөх эрсдэлтэй эмзэг болон гадуурхагдсан бүлгийнхнийг оролцуулан, хүн бүрийн хоол хүнсээр хангагдах эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэхийн тулд Актад тусгагдсан олон чухал асуудалд анхаарлаа хандуулахыг Непалын засгийн газарт уриалж байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

ИНДЕКС: ASA 31/0130/2019

2019 ОНЫ 4 САР

ХЭЛ: АНГЛИ

[amnesty.org](http://amnesty.org)

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ






**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ  
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ  
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.**


**НЭГ Л ХҮНИЙ ЭРХ  
ЗӨРЧИГДВӨЛ ЭНЭ НЬ БИД  
БҮГДЭД ХАМААТАЙ.**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

 [info@amnesty.org](mailto:info@amnesty.org)  
[mongolia.amnesty@gmail.com](mailto:mongolia.amnesty@gmail.com)

 +44 (0)20 7413 5500  
+976 7000 4708

 [www.facebook.com/AmnestyGlobal](http://www.facebook.com/AmnestyGlobal)  
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)  
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл

 @AmnestyOnline